



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2025 оны 06 сарын 13 өдөр

Дугаар A/13

Улаанбаатар хот

«Багахангай дүүргийн баяр наадмын хугацааг  
тогтоох, зохион байгуулах хороо, салбар  
хорооны бүрэлдэхүүнийг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх хэсэг, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус IV дүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Багахангай дүүргийн баяр наадмыг 2025 оны 07 дугаар сарын 09, 10-ны өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүлсүгэй.

2.Дүүргийн баяр наадмыг зохион байгуулах хорооны бүрэлдэхүүнийг нэгдүгээр, салбар хороодын бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Баяр наадмын бэлтгэлийг сайтар ханган, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны A/20 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтаар батлагдсан үндэсний бөх, сурын харваа, хурдан морь, шагайн харвааны дүрмийн хүрээнд өндөр түвшинд зохион байгуулж ажиллахыг дүүргийн Засаг дарга (А.Сүхболд)-д даалгасугай.

4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд үүрэг болгосугай.

ДАРГА



Ф.МӨНХГЭРЭЛ